

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 05 дугаар сарын 15-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-6

*1.Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл
/Засгийн газар 2026.05.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/* 3-6

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны
05 дугаар сарын 15-ны өдөр /Баасан гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 53.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 30 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, П.Ганзориг, Ц.Даваасүрэн, Л.Мөнхбаясгалан;
Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Д.Пүрэвдаваа, Г.Тэмүүлэн;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар, Б.Мөнхсоёл, П.Мөнхтулга,
Д.Энхтүвшин.

Нэг.Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Сангийн сайд З.Мэндсайхан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн тавьсан асуултад Сангийн сайд З.Мэндсайхан хариулж, тайлбар хийв.

Н.Наранбаатар: Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 2
Бүгд: 17
88.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 12 минут үргэлжилж, ирвэл зохих 30 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 63.3 хувийн ирцтэйгээр 10 цаг 42 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Н.НАРАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 05 дугаар сарын 15-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
10 цаг 30 минут.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Наранбаатар: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж, ирц 53,3 хувьтай бүрдсэн тул Төсвийн байнгын хорооны 2026 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүдийн нэрээр нь танилцуулна. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Жигжидийн Батжаргал, Хөххүүгийн Болормаа, Батжаргалын Заяабал, Пүрэвжавын Сайнзориг, Доржсүрэнгийн Үүрийнтуяа, Далайн Батбаяр, Жамбын Батсуурь, Хүрэлбаатарын Булгантуяа, Нанзаддын Наранбаатар, Банзрагчийн Түвшин, Ренчиндоржийн Батболд, Жадамбаагийн Баясгалан, Хассуурийн Ганхуяг, Чинбатын Номин, Баттогтохын Чойжилсүрэн.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1.Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл, Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 5 сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх. Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Саналтай гишүүн байхгүй бол хэлэлцэх асуудалдаа орно.

Гадаадын зээллэгийн ашиглалт үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. 2026 оны 5 сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэхийг шийдвэрлэсэн. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Чулууны Хишигдалай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга, Огнонгийн Хуягцогт Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Уранбаатарын Чинзориг Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн Гэрээ, эрх зүйн газрын дарга.

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан танилцуулна.

З.Мэндсайхан: Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлаас соёрхон баталсан олон улсын гэрээ хэлэлцээр бүхий гадаад зээлийн төслүүдийн эх үүсвэрийн ашиглалтыг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх, тэр дундаа үндэсний аюулгүй байдлыг хангах стратегийн төслүүдийг хугацаанд нь ашиглалтад оруулах зорилготой Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы 2026 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

Монгол Улсын Засгийн газар 1991 оноос хойш нийт 308 төсөл, арга хэмжээнд 10,4 тэрбум ам.доллар буюу 33,4 их наяд төгрөгийн төслийн зээлийн хэлэлцээр байгуулснаас өнөөдрийн байдлаар 6,1 тэрбум ам.доллар буюу 19,6 их наяд төгрөгийн хөрөнгө ашиглаж, 4,3 тэрбум ам.доллар буюу 13,8 их наяд төгрөгийн ашиглаагүй үлдэгдэл байгаагийн 38 хувь нь буюу 5,3 их наяд нь газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын төслүүдийн үлдэгдэл санхүүжилт байна. Хэрэгжиж буй төслүүдийн 68 хувь буюу 52 нь төсөл нь хөнгөлөлттэй, 32 буюу 22 төсөл нь нэн хөнгөлөлттэй нөхцөлөөр хэрэгжиж байгаагаас гадна зарим төслүүд зээлийн эх үүсвэрийг дагасан тусламжийн санхүүжилтийг тодотгох нь зүйтэй байна.

Нэн хөнгөлөлттэй болон хөнгөлөлттэй зээл нь Монгол Улсын төсөвт ирэх шууд ачааллыг бууруулж, дунд болон урт хугацааны хөгжлийн суурийг тавих чухал үүрэг гүйцэтгэсээр байгаа хэдий ч 2011 оноос нэн хөнгөлөлттэй нөхцөл өөрчлөгдөж, Монгол Улс энгийн болон хөнгөлөлттэй зээлд хамрагдах болсон. Харин 2024 оноос эхлэн манай улс дунджаас дээгүүр орлоготой улс болсон тул арилжааны нөхцөлтэй зээл авахаар зээлийн нөхцөл өөрчлөгдөж байна. Нийт зээлийн төслүүдийн 13,8 их наяд төгрөгийн ашиглаагүй үлдэгдлийн 98 хувь нь 2026-аас 2029 онд хэрэгжиж дуусах гэрээ хэлэлцээртэй байгаа нь ирэх 3 жилд зээлийн ашиглалтыг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх үндэслэл бөгөөд зээлийн ашиглалтыг Улсын Их Хурлаар соёрхон баталсан хэлэлцээрийн хугацаанд багтаан хэрэгжүүлэхгүй тохиолдолд төслийн хугацаа хойшлох, өртөг өсөх, хүүгийн болон үйлчилгээний зардал нэмэгдэх, улмаар хөрөнгө оруулалтын төслүүд хугацаандаа ашиглалтад ороогүйгээс үүдэн нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр өгөөж саарах бодит эрсдэлийг бий болгож байна.

Нөгөө талдаа Улсын Их Хурлаар соёрхон баталсан гэрээ хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуульд зааснаар олон улсын гэрээнд хамаардаг бөгөөд энэ үүднээс олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, олон улс санхүүгийн байгууллагын тогтмол хийгддэг үнэлгээнд нөлөөлөх асуудал юм. Өнөөдрийн энэ төсвийн хязгаарлалттай нөхцөл байдлаас шалтгаалаад гадаад зээлийн эх үүсвэртэй төслүүдийн гэрээний дагуух шаардлагатай санхүүжилтийн 22 орчим хувийг улсын төсөвт тусгаж байгаа нь хэрэгжилтийн гол хүндрэл болж байна. Зээлийн ашиглалтыг нэмэгдүүлэхгүйгээр энэ түвшнийг хэвээр үргэлжлүүлбэл зарим төслийн хэрэгжилт 5-аас 10 жилээр хойшлох, зардал нэмэгдэх, өрийн үйлчилгээний төлбөр нэмэгдэх бодит эрсдэл үүссэн.

Энэ нь энэ онд 18 төсөл хэрэгжиж дуусаж байгаа боловч шинээр эхлэх төслүүдийн гэрээтэй холбоотойгоор зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл ирэх онуудад ч өндөр хэвээр байх хандлагатай байна. Иймд Улсын Их Хурал, Засгийн газрын түвшинд гадаад зээлийн ашиглалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын болон эрх зүйн зохицуулалтыг оновчтой болгох шаардлага үүссэн тул Гадаад зээлийн

ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна.

Хуулийн төсөл 4 бүлэг, 5 зүйлтэй бөгөөд хуулийн 1 дүгээр бүлэгт хуулийн зорилт, хуулийн үйлчлэх хүрээг, 2 дугаар бүлэгт гадаад зээлийн ашиглалтын зардлын зохицуулалтыг, 3 дугаар бүлэгт гадаад зээлийн ашиглалтын ил тод байдал, хяналтын асуудлыг, 4 дүгээр бүлэгт хуулийн дагаж мөрдөх журмын зохицуулалтыг тус тус тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар 2026 онд газрын тос боловсруулах үйлдвэрийн 1,5 их наяд, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын төслийн хувьд 324,1 тэрбум төгрөгийн ашиглалт буюу нийт 1,8 их наяд төгрөгийн санхүүжилт гарснаар төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлж, хэлэлцээрийн хугацаанд багтаан ашиглалтад оруулснаар зээлийн үйлчилгээний төлбөр, тэр дундаа хөрөнгө баталгаажуулсны төлбөрт төлөгдөх 104,1 тэрбум төгрөгийг хэмнэх нөхцөл бүрдэнэ. Газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орсноор дотоодын хэрэглээний 55 хувийг хангаж, жил бүр 1 тэрбум ам.доллар дотооддоо үлдэх, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын хувьд баруун бүсийг 100 хувь эрчим хүчээр хангаж, жил бүр 17,5 тэрбум төгрөг дотооддоо үлдэж импортын цахилгаан эрчим хүчийг орлохоор байна. Иймд хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Н.Наранбаатар: Мэндсайхан сайдад баярлалаа. Танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье? Сайнзориг гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Би энийг яаралтай хэлэлцэж батлуулахын тулд зүгээр ганцхан юм асууя. Сэлбийг хассанаас бусад яг батлагдах гэж байсан хувилбараас юу өөрчлөгдсөн бэ? Тэрийг яг ингээд Байнгын хорооны гишүүдэд бас хэлчихвэл ажлын хэсэг энэ тэр гэж элдэв зүйл болохгүйгээр шууд анхны хэлэлцүүлгээр нь батлах тийм чиглэл рүү явъя гэсэн бодолтой байна. Энийг сайд нэг хариулаад өгчхөөч.

Н.Наранбаатар: Сангийн сайд хариулъя, 6 номерын микрофон.

З.Мэндсайхан: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Өмнөх хуулийн төслөөс зөвхөн Сэлбийн дэд төсөл хасагдсан, бусдаар өөрчлөгдсөн зүйл байхгүй.

Н.Наранбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье? Алга байна. Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт явуулна. Батбаяр гишүүн юундаа ороогүй байна, бэлтгээгүй байна. Болормаа гишүүн бэлтгээгүй байна. Сайнзориг гишүүн бэлтгээгүй байна, орчихсон уу? Үүрийнтуяа гишүүн бэлтгээгүй байна, орчихлоо. Ингээд 12 болж байна. Булгантуяа гишүүн санал хураалтаа бэлтгэе. Батсуурь гишүүнийх ороогүй байна. Булгантуяа гишүүнийх бэлэн болоогүй байна. Авсан, авсан асуулт асуусан. Санал хураалтын томъёоллыг уншиж танилцуулъя.

Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Явчихсан. Санал хураалт. 15 гишүүн дэмжиж, 88,2 хувиар дэмжигдлээ. Хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын

Их Хурлын гишүүн Наранбаатар танилцуулна. Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

10.42 цаг

Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА